



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/156/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймгийн Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com
Аудитор: Ц.Энхтуяа
Утас: 99042645 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сајт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Э.ЧАНЦАЛДУЛАМ ТАНАА
2022.02.28 № 1-6/164 танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Э.Чанцалдуламд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК -ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төв нь орон нутгийн хүн амын хэрэгцээнд нийцсэн түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй, цаг алдалгүй, чанартай эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болон НЭМ-ийн тусламж үзүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн газар эмчилгээ үйлчилгээ явуулах

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 47 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 307,334.3 мянган төгрөгөөс тооцон 6,146.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,811.9 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	926.2	926.2	-
Бараа материал	25,622.4	44,293.5	18,671.0
Үндсэн хөрөнгө	234,663.1	267,803.9	33,140.8
Нийт хөрөнгө	261,211.8	313,023.6	51,811.9
Өр төлбөр	913.8	933.8	20.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	260,298.0	312,089.8	51,791.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	261,211.8	313,023.6	51,811.9

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материалын 4.0 мянган төгрөгөөр, эм боох материал 26,505.7 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 5,448.3 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 8,876.0 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 2,540.1 мянган төгрөгөөр, түлш шатахуун 23,001.8 мянган төгрөгөөр, засварын материал 882.7 мянган төгрөгөөр, хүнсний материал 5,305.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж нийт 53,010.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 18,671.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдах буюу ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 8,964.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр бэлтгэсэн, 43,090.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авснаас шалтгаалан үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үндсэн хөрөнгө шинээр бэлтгэсэн, хуримтлагдсан үр дүнгээс хамаарч 51,791.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийг тайлант онд нийт 308,900.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 309,654.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 100.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	-	1,100.8	1,100.8	-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,198.9	279,198.9	-	100
Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,762.4	10,762.4	-	100
Хандив тусламж /дотоод/	18,939.3	18,592.4	(346.9)	98.2
Нийт дүн	308,900.6	309,654.5	753.9	100.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын төлөвлөгөөг бодиттой үнэн зөв төлөвлөдөггүй алдаа байна.

Урсгал зардлыг 1,566.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1,332.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5.8 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 58.6 мянган төгрөгөөр, норматив зардлыг 30.7 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 236.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 36,059.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин 15,16.6 мянган төгрөг, урамшуулал 926.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардалд 1,721.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 17,035.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,138.8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 2 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 53.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг төлбөрийн акт тогтоолоо.

Залилангийн эрсдэл

Тус эрүүл мэндийн төв нь дотоод албан томилолтыг олгохдоо хоногийн тооцоог буруу бодож баримтгүй 2 хоногийн нийт 53.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 1992 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Албан томилолтын зардал олгох заавар”, Төсвийн тухай хуулийн 6.4.1. *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*; заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах

ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант хугацаанд нийт 926.2 мянган төгрөгийн авлага, 933.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл тус тус тайлагнасан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 6.4.8. *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Авлага, өглөгийг барагдуулаагүй байх, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 20ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,548,685.78</u>	<u>45,219,714.49</u>
33	АВЛАГА	926,236.00	926,236.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	926,236.00	926,236.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,622,449.78	44,293,478.49
351	Түүхий эд материал	3,281,224.68	13,212,559.68
35110	Тусгай зориулалттай материал	1,682,723.00	1,686,723.00
35130	Эм боох материал	1,598,501.68	11,525,836.68
354	Хангамжийн материал	22,341,225.10	31,080,918.81
35410	Бичиг хэргийн материал	1,025,540.00	3,864,240.00
35420	Аж ахуйн материал	14,591,926.00	16,996,579.31
35440	Түлш, шатах тослох материал	3,724,390.00	4,878,890.00
35460	Хүнсний материал	2,999,369.10	5,341,209.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>234,663,101.90</u>	<u>267,803,932.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>234,663,101.90</u>	<u>267,803,932.03</u>
392	Биет хөрөнгө	<u>226,663,101.90</u>	<u>259,803,932.03</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	174,397,644.00	189,397,644.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,207,856.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,785,000.00	31,785,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,329,055.62)	(7,635,889.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,254,728.00	60,661,628.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,245,308.81)	(39,763,952.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,791,989.00	12,141,489.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,990,712.86)	(5,901,557.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	85,374,469.00	99,672,469.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,375,650.81)	(77,345,042.81)
393	Биет бус хөрөнгө	<u>8,000,000.00</u>	<u>8,000,000.00</u>
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.00)	(385,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>261,211,787.68</u>	<u>313,023,646.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>913,829.00</u>	<u>933,827.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	913,829.00	933,827.00
413	Өглөг	913,829.00	933,827.00
4136	Бусад өглөг	913,829.00	933,827.00
41361	Байгууллагад төлөх өглөг	29,460.00	29,460.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	884,369.00	904,367.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>260,297,958.68</u>	<u>312,089,819.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	260,297,958.68	312,089,819.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	236,581,519.55	236,581,519.55
51101	Өмч: - төрийн	236,581,519.55	236,581,519.55
512	Хуримтлагдсан үр дүн	(54,648,413.61)	(2,856,552.77)
51210	Өмнөх үеийн үр дүн	(54,648,413.61)	(54,648,413.61)
51220	Тайлант үеийн үр дүн	-	51,791,860.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,364,852.74	78,364,852.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>261,211,787.68</u>	<u>313,023,646.52</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	232,985,035.75	352,744,490.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,240,006.75	340,881,290.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,240,006.75	43,090,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,240,006.75	43,090,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,240,006.75	43,090,000.00
122	Тусламжийн орлого	-	18,592,390.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	18,592,390.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	279,198,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	279,198,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,745,029.00	11,863,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	228,474,600.00	10,762,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	228,474,600.00	10,762,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,270,429.00	1,100,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,270,429.00	1,100,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	251,596,044.45	300,952,629.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,596,044.45	300,952,629.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,466,447.45	298,632,421.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,462,182.00	185,364,555.00
210101	Үндсэн цалин	134,508,728.00	140,500,000.00
210102	Нэмэгдэл	-	32,099,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,968,787.00
210104	Урамшуулал	5,953,454.00	10,796,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,800,905.00	23,106,802.00
210201	Тэтгэврийн даатгал	11,292,176.00	15,757,873.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,202,274.00	1,797,413.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,206,396.00	1,534,954.00
210204	Ажилгүйдлийн даатгал	281,823.00	364,464.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,818,236.00	3,652,098.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,513,315.00	9,431,609.00
210301	Гэрэл, цахилгаан	1,619,715.00	1,340,609.00
210302	Түлш, халаалт	6,591,000.00	7,791,000.00
210303	Цэвэр, бохир ус	302,600.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,656,419.00	23,787,275.69
210401	Бичиг хэрэг	597,700.00	2,614,450.00
210402	Тээвэр, шатахуун	11,710,150.00	14,169,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	422,500.00	845,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	671,474.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	254,595.00	6,037,895.69
2105	Нормативт зардал	19,734,159.33	19,678,435.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,185,785.93	16,578,380.00
210502	Хоол, хүнс	2,548,373.40	3,100,055.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,995,999.00	2,988,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,999.00	
210604	Урсгал засвар	1,936,000.00	2,988,600.00
2107	Томилот, зочны зардал	925,000.00	1,763,500.00
210701	Гадаад албан томилот	925,000.00	1,763,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,662,727.00	11,904,574.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,439,707.00	11,548,364.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	160,000.00

Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	7,000.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,020.00	51,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	15,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,715,741.12	20,607,069.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,698,100.00	1,693,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,017,641.12	18,913,569.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,129,597.00	2,320,208.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,129,597.00	2,320,208.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,129,597.00	2,320,208.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,611,008.70)	51,791,860.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	58,001,787.80	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	58,001,787.80	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(58,001,787.80)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(76,612,796.50)	51,791,860.84

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	229,745,029.00	309,654,490.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		297,791,290.00
122	Тусламжийн орлого	-	18,592,390.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	18,592,390.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	279,198,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	279,198,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,745,029.00	11,863,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	229,745,029.00	11,863,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	228,474,600.00	10,762,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,270,429.00	1,100,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,270,429.00	1,100,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	228,220,029.00	300,690,090.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,220,029.00	300,690,090.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,090,432.00	298,369,882.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,690,847.00	185,365,355.00
210101	Үндсэн цалин	134,390,847.00	140,500,000.00
210102	Нэмэгдэл	-	32,100,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,968,787.00
210104	Урамшуулал	6,300,000.00	10,796,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,238,841.00	23,106,802.00
210201	Тэтгэврийн даатгал	11,602,369.00	15,795,227.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,318,317.00	1,797,413.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,218,096.00	1,497,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	281,823.00	364,464.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,818,236.00	3,652,098.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,933,315.00	8,906,609.00
210301	Гэрэл, цахилгаан	1,619,715.00	1,340,609.00
210302	Түлш, халаалт	7,017,000.00	7,266,000.00
210303	Цэвэр, бохир ус	296,600.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,804,766.00	23,537,881.00
210401	Бичиг хэрэг	442,800.00	2,482,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,556,400.00	15,594,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	616,600.00	1,800,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,188,966.00	660,779.00

Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,999,872.00
2105	Нормативт зардал	18,759,826.00	31,469,961.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,270,629.00	24,475,665.00
210502	Хоол, хүнс	2,880,197.00	4,999,396.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	609,000.00	1,994,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,324,348.00	4,133,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	224,499.00	2,285,000.00
210604	Урсгал засвар	2,099,849.00	1,848,600.00
2107	Томилолт, зочны зардал	950,000.00	1,763,500.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	1,763,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,388,489.00	13,613,274.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,165,469.00	13,257,064.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,000.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,020.00	51,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	15,000.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	6,472,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	6,472,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,129,597.00	2,320,208.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,129,597.00	2,320,208.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,129,597.00	2,320,208.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,525,000.00</u>	<u>8,964,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,525,000.00	8,964,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,525,000.00	8,964,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,525,000.00	8,964,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,525,000.00	8,964,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,525,000.00)</u>	<u>(8,964,400.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,581,519.55	19,709,737.94	23,548,032.46	271,839,289.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,581,519.55	19,709,737.94	23,548,032.46	271,839,289.95
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,583,649.57)	(1,583,649.57)
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	(54,648,413.61)	260,297,958.68
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	(54,648,413.61)	260,297,958.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	(54,648,413.61)	260,297,958.68
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	51,791,860.84	51,791,860.84
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,581,519.55	78,364,852.74	(2,856,552.77)	312,089,819.52

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	308,900,600.00	307,334,282.00	(1,566,318.00)	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	308,900,600.00	307,334,282.00	(1,566,318.00)	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,900,600.00	307,334,282.00	(1,566,318.00)	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,520,000.00	185,365,355.00	(154,645.00)	99.9
210101	Үндсэн цалин	140,500,000.00	140,500,000.00	-	100.0
210102	Нэмэгдэл	32,100,000.00	32,100,000.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,120,000.00	1,968,787.00	(151,213.00)	92.9
210104	Урамшуулал	10,800,000.00	10,796,568.00	(3,432.00)	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,439,500.00	23,106,802.00	(1,332,698.00)	94.5
210201	Тэтгэврийн даатгал	16,951,500.00	15,795,227.00	(1,156,273.00)	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,872,000.00	1,797,413.00	(74,587.00)	96.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,600.00	1,497,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	374,400.00	364,464.00	(9,936.00)	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3,744,000.00	3,652,098.00	(91,902.00)	97.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,912,400.00	8,906,609.00	(5,791.00)	99.9
210301	Гэрэл, цахилгаан	1,342,400.00	1,340,609.00	(1,791.00)	99.9
210302	Түлш, халаалт	7,270,000.00	7,266,000.00	(4,000.00)	99.9
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,096,500.00	24,037,881.00	(58,619.00)	99.8
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,482,500.00	(17,500.00)	99.3
210402	Тээвэр, шатахуун	15,596,500.00	15,594,730.00	(1,770.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,160,779.00	(39,221.00)	96.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,999,872.00	(128.00)	100.0
2105	Нормативт зардал	31,500,700.00	31,469,961.00	(30,739.00)	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,084,400.00	24,475,665.00	391,265.00	101.6
210502	Хоол, хүнс	5,416,300.00	4,999,396.00	(416,904.00)	92.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,994,900.00	(5,100.00)	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,600,000.00	12,598,000.00	(2,000.00)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,550,000.00	7,549,900.00	(100.00)	100.0
210602	Тавилга	3,200,000.00	3,199,500.00	(500.00)	100.0
210604	Урсгал засвар	1,850,000.00	1,848,600.00	(1,400.00)	99.9
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,763,500.00	(236,500.00)	88.2
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,763,500.00	(236,500.00)	88.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,358,600.00	13,613,274.00	254,674.00	101.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,550,400.00	13,257,064.00	706,664.00	105.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	160,000.00	(450,000.00)	26.2
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	98,010.00	(1,990.00)	98.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.00	51,200.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	15,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,472,900.00	6,472,900.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,472,900.00	6,472,900.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	308,900,600.00	309,654,490.00	753,890.00	100.2

Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	279,198,900.00	280,299,700.00	1,100,800.00	100.4
131001	Улсын төсвөөс санхүүжих		1,100,800.00	1,100,800.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,198,900.00	279,198,900.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,762,400.00	10,762,400.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	10,762,400.00	10,762,400.00	-	100.0
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	18,939,300.00	18,592,390.00	(346,910.00)	98.2
122001	Хандив тусламж /дотоод/	18,939,300.00	18,592,390.00	(346,910.00)	98.2

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,059,406.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,059,406.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,059,406.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,163,624.00
210101	Үндсэн цалин	14,237,302.00
210104	Урамшуулал	926,322.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,721,892.00
210201	Тэтгэврийн даатгал	1,192,029.00
210202	Тэтгэмжийн даатгал	136,832.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	101,571.00
210204	Ажилгүйдлийн даатгал	26,509.00
210205	Эрүүл мэндийн даатгал	264,951.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,035,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,035,090.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,138,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,138,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,059,406.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	